

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2022/178/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаангом хот
2022 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,
Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь
Утас: 70453317, Цахим хаяг: BatsuuriM@audit.gov.mn
Аудитын менежер: М.Бат-Амгалан
Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn
Ахлах аудитор: Б.Авирмэд
Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2022.02.25 № УВА-2022/178/17-СТА-ТШЗ
танай _____ -ны № _____ -т

БӨХМӨРӨН СУМЫН ЭРҮҮЛ
МЭНДИЙН ТӨВИЙН ДАРГА
М.ОЮУНЧИМЭГ ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд 9178.6 мянган төгрөгийн 3996 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үйлдээгүй, зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулсан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 зүйлийн 20.1.4 заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасантай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

0200200389

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

Агуулга

| | |
|--|----|
| 1. Аудитын санал дүгнэлт..... | 1 |
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 3 |
| 3. Аудитын тайлан | 6 |
| 3.1 Ерөнхий зүйл | 12 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт..... | 12 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал | 12 |
| 3.4 Материаллаг байдал..... | 13 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 13 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 13 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг | 15 |
| 3.8 Аудитын гол асуудал..... | 15 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал | 15 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 16 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 16 |
| 4. Аудитын илрүүлэлт..... | 16 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 17 |

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт

2.1. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|------------------------------------|------------------------------|------------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>30,715,092.89</u> | <u>130,310,530.16</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 00.00 | 15,524,416.86 |
| 312 | Банканд байгаа бэлэн мөнгө | 00.00 | 15,524,416.86 |
| 3121 | Төгрөг | 00.00 | 15,524,416.86 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 7,550,302.73 |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | 00.00 | 7,974,114.13 |
| 33 | АВЛАГА | 3,114,509.15 | 78,679,809.15 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 1,285,074.70 | 1,285,074.70 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | 00.00 | 77,015,300.00 |
| 335 | Бусад авлага | 1,829,434.45 | 379,434.45 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 1,450,000.00 | 00.00 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 379,434.45 | 379,434.45 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 27,600,583.74 | 36,106,304.15 |
| 351 | Түүхий эд материал | 10,173,657.00 | 16,403,283.50 |
| 35130 | Эм боох материал | 10,173,657.00 | 16,403,283.50 |
| 354 | Хангамжийн материал | 17,126,926.74 | 19,403,020.65 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 2,478,700.00 | 2,763,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,876,587.00 | 15,229,737.40 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 294,900.00 | 1,063,900.00 |
| 35460 | Хүнсний материал | 476,739.74 | 346,183.25 |
| 35600 | Мал амьтад | 300,000.00 | 300,000.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>387,665,344.23</u> | <u>420,073,387.15</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 387,665,344.23 | 420,073,387.15 |
| 392 | Биет хөрөнгө | 382,027,344.23 | 414,435,387.15 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 272,866,570.00 | 271,944,840.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -18,763,263.69 | -28,045,014.69 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 73,943,769.00 | 91,686,884.50 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -18,986,269.00 | -14,752,467.82 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 126,143,456.00 | 162,864,905.56 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -62,667,857.56 | -75,880,056.36 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 24,806,146.00 | 21,107,730.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -15,315,206.52 | -14,491,434.04 |
| 393 | Биет бус хөрөнгө | 5,638,000.00 | 5,638,000.00 |
| 39301 | Программ хангамж | 440,000.00 | 440,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -440,000.00 | -440,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 5,638,000.00 | 5,638,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>418,380,437.12</u> | <u>550,383,917.31</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>339,873.57</u> | <u>9,710,754.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 339,873.57 | 9,710,754.00 |
| 413 | Өглөг | 339,873.57 | 9,710,754.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 65,576.57 | 8,530,434.00 |
| 4136 | Бусад өглөг | 274,297.00 | 1,180,320.00 |

| | | | |
|------------|---|-----------------------|-----------------------|
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 8,887.00 | 1,180,320.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 265,410.00 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 418,040,563.55 | 540,673,163.31 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 418,040,563.55 | 540,673,163.31 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 189,564,832.00 | 189,564,832.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 189,564,832.00 | 189,564,832.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 88,729,152.88 | 212,283,482.64 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 88,729,152.88 | 89,650,882.88 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 122,632,599.76 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 139,746,578.67 | 138,824,848.67 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 418,380,437.12 | 550,383,917.31 |

2.2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|------------|--|-----------------------|-----------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 449,790,420.00 | 774,273,700.46 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 395,072,000.00 | 513,726,140.46 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 53,998,900.00 | 111,437,940.46 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 53,998,900.00 | 111,437,940.46 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 53,998,900.00 | 111,437,940.46 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 341,073,100.00 | 402,288,200.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 341,073,100.00 | 402,288,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 54,718,420.00 | 260,547,560.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 11,306,800.00 | 130,894,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,306,800.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 130,894,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 20,820,600.00 | 34,106,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,820,600.00 | 34,106,600.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 22,591,020.00 | 95,546,060.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,591,020.00 | 95,546,060.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 416,277,835.60 | 629,587,668.46 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 416,277,835.60 | 629,587,668.46 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 413,601,350.21 | 595,182,729.46 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 276,242,956.00 | 348,011,816.00 |
| 210101 | Үндсэн цалин | 248,924,834.00 | 311,271,732.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,996,000.00 | 4,503,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,663,582.00 | 27,197,084.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 4,658,540.00 | 5,040,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 33,964,057.18 | 43,039,223.57 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,771,755.14 | 31,309,293.01 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,732,562.39 | 3,153,426.22 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,284,971.10 | 2,457,162.47 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 470,467.44 | 556,303.76 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,704,301.11 | 5,563,038.11 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,142,497.00 | 23,567,164.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,443,887.00 | 3,187,848.00 |
| 210302 | Түлш, халаалт | 15,698,610.00 | 20,379,316.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 26,148,750.00 | 38,280,150.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,855,050.00 | 1,932,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,260,650.00 | 27,130,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,246,650.00 | 1,325,300.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 475,000.00 | 825,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,447,700.00 | 3,532,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 863,700.00 | 3,534,000.00 |

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|----------------------|-----------------------|
| 2105 | Нормативт зардал | 22,421,706.78 | 99,199,095.49 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 17,407,713.00 | 87,294,679.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,013,993.78 | 11,904,416.49 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 895,000.00 | 3,638,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 100,000.00 | 279,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 795,000.00 | 3,359,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 150,000.00 | 800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 150,000.00 | 800,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 782,032.00 | 714,006.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,200.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 360,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 52,600.00 | 50,540.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 533,500.00 | 264,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46,732.00 | 39,466.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 33,854,351.25 | 37,933,274.40 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 213,580.00 | 1,533,300.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 33,640,771.25 | 36,399,974.40 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 2,676,485.39 | 34,404,939.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 00.00 | 27,600,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 27,600,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 2,676,485.39 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 6,804,939.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 6,804,939.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 33,512,584.40 | 144,686,032.00 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 00.00 | 22,053,432.24 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 22,053,432.24 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | -22,053,432.24 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 33,512,584.40 | 122,632,599.76 |

2.3. АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 395,791,520.00 | 586,820,460.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 341,073,100.00 | 402,288,200.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 341,073,100.00 | 402,288,200.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 341,073,100.00 | 402,288,200.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 54,718,420.00 | 184,532,260.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 11,306,800.00 | 131,894,900.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 11,306,800.00 | 00.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 00.00 | 131,894,900.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 20,820,600.00 | 34,106,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 20,820,600.00 | 34,106,600.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | 22,591,020.00 | 18,530,760.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,591,020.00 | 18,530,760.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 395,791,520.00 | 571,296,043.14 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 395,791,520.00 | 571,296,043.14 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 392,115,034.61 | 536,891,104.14 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 276,047,605.00 | 336,936,257.00 |
| 210101 | Үндсэн цалин | 248,348,023.00 | 300,196,173.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 4,996,000.00 | 4,503,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,663,582.00 | 27,197,084.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 5,040,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 34,093,831.61 | 45,649,925.14 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 23,901,529.57 | 34,304,958.51 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 2,732,562.39 | 3,033,880.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,284,971.10 | 2,427,102.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 470,467.44 | 534,907.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 4,704,301.11 | 5,349,076.07 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 19,583,610.00 | 22,908,251.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,435,000.00 | 2,978,935.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,148,610.00 | 19,929,316.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 25,147,800.00 | 35,922,350.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,374,050.00 | 1,849,050.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 20,260,650.00 | 27,130,800.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,311,300.00 | 1,543,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 80,400.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,087,500.00 | 1,699,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,033,900.00 | 3,699,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 29,717,386.00 | 71,867,105.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 23,670,431.00 | 59,362,620.00 |

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|---------------------|----------------------|
| 210502 | Хоол, хүнс | 5,246,955.00 | 11,778,485.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 800,000.00 | 726,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,286,990.00 | 20,370,910.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 3,800,000.00 | 4,500,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 250,000.00 | 11,477,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,236,990.00 | 4,393,410.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 150,000.00 | 800,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 150,000.00 | 800,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 782,032.00 | 714,006.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 29,200.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 120,000.00 | 360,000.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 52,600.00 | 50,540.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 533,500.00 | 264,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 46,732.00 | 39,466.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,305,780.00 | 1,722,300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,305,780.00 | 1,722,300.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 3,676,485.39 | 34,404,939.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 00.00 | 27,600,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 27,600,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 3,676,485.39 | 00.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 00.00 | 6,804,939.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 6,804,939.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 00.00 | 15,524,416.86 |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | 00.00 | 00.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 15,524,416.86 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 15,524,416.86 |

2.4. АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН

/Төгрөгөөр /

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|--|---------------------------------|-----------------------|-----------------------|--|
| 2020 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 183,926,832.00 | 00.00 | 9,696,521.90 | 193,623,353.90 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 183,926,832.00 | 00.00 | 9,696,521.90 | 193,623,353.90 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 37,999,935.33 | 37,999,935.33 |
| 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 189,564,832.00 | 139,746,578.67 | 88,729,152.88 | 418,040,563.55 |
| 2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 189,564,832.00 | 139,746,578.67 | 88,729,152.88 | 418,040,563.55 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 921,730.00 | 921,730.00 |
| Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 189,564,832.00 | 139,746,578.67 | 89,650,882.88 | 418,962,293.55 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -921,730.00 | 00.00 | -921,730.00 |
| Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 122,632,599.76 | 122,632,599.76 |
| 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 189,564,832.00 | 138,824,848.67 | 212,283,482.64 | 540,673,163.31 |

2.5. АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|-----------------------|---|-----------------------|----------------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 459,308,000.00 | 440,570,318.27 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 459,308,000.00 | 440,570,318.27 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 459,308,000.00 | 440,570,318.27 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 303,936,600.00 | 303,181,090.00 |
| 210101 | Үндсэн цалин | 266,671,000.00 | 269,940,506.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 5,544,000.00 | 4,503,000.00 |
| 210104 | Урамшуулал | 26,681,600.00 | 23,697,584.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,040,000.00 | 5,040,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 41,031,500.00 | 34,924,901.27 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 28,874,000.00 | 23,579,934.64 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,039,400.00 | 3,033,880.52 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,431,500.00 | 2,427,102.50 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 607,900.00 | 534,907.54 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,078,700.00 | 5,349,076.07 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 29,506,600.00 | 22,908,251.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,826,700.00 | 2,978,935.00 |
| 210302 | Түлш, халаалт | 24,359,900.00 | 19,929,316.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 320,000.00 | 00.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 30,232,600.00 | 29,553,400.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,400,000.00 | 1,397,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 21,886,000.00 | 21,713,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,546,600.00 | 1,543,100.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 100,000.00 | 00.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 2,100,000.00 | 1,699,700.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,200,000.00 | 3,199,700.00 |
| 2105 | Нормативт зардал | 37,280,000.00 | 36,914,960.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 28,680,000.00 | 28,657,410.00 |
| 210502 | Хоол, хүнс | 7,600,000.00 | 7,531,550.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,000,000.00 | 726,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,100,000.00 | 9,851,410.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,500,000.00 | 4,500,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,000,000.00 | 958,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 4,600,000.00 | 4,393,410.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,150,000.00 | 800,000.00 |

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 210702 | Дотоод албан томилолт | 1,150,000.00 | 800,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,432,500.00 | 714,006.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 300,000.00 | 00.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 360,000.00 | 360,000.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 91,900.00 | 00.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 52,600.00 | 50,540.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 44,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 532,000.00 | 264,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 52,000.00 | 39,466.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4638200.00 | 1722300.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 4,638,200.00 | 1,722,300.00 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 459,308,000.00 | 448,120,621.00 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 402,288,200.00 | 402,288,200.00 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 34,106,600.00 | 27,301,661.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 34,106,600.00 | 27,301,661.00 |
| 1340 | НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 22,913,200.00 | 18,530,760.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 22,913,200.00 | 18,530,760.00 |
| 5 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 7,550,302.73 |
| 62 | АЖИЛЛАГСДЫН ТОО | 21.00 | 21.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 15.00 | 15.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 04.00 | 04.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 01.00 | 01.00 |

2.6. АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|------------|--|----------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 123,920,785.87 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 123,920,785.87 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 96,320,785.87 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 33,755,167.00 |
| 210101 | Үндсэн цалин | 30,255,667.00 |
| 210104 | Урамшуулал | 3,499,500.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 10,725,023.87 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 10,725,023.87 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,368,950.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 451,550.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 5,417,400.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 500,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 34,952,145.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 30,705,210.00 |
| 210502 | Хоол, хүнс | 4,246,935.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 10,519,500.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 10,519,500.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 27600000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 27,600,000.00 |
| 213203 | Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж | |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 27,600,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 131894900.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 131,894,900.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 131,894,900.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 02 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төв нь иргэдэд Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг шуурхай, чанартай, хүртээмжтэй хүргэх гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг төсвийн тухай хуульд өөрчлөлт орсон байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 3.1 сая төгрөгөөр тогтоосныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 629.8 сая төгрөгийн 1 хувь буюу 6.2 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 5.0 сая төгрөгөөр тогтоолоо.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн тайлан гараагүй байсан тул материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар дахин шинэчлэн тогтоолоо.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бөхмөрөн сумын эрүүл мэндийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 132,003.5 мянган төгрөгөөр буюу 31.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс өөрчлөлт гарсан мөнгөн хөрөнгө, авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|------------------|------------------|------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | 0 | 15,524.4 | 15,524.4 |
| Авлага | 3,114.5 | 78,679.8 | 75,565.3 |
| Урьдчилгаа | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 27,600.6 | 36,106.3 | 8,505.7 |
| Үндсэн хөрөнгө | 387,665.3 | 420,073.4 | 32,408.1 |
| Нийт хөрөнгө | 418,380.4 | 550,383.9 | 132,003.5 |
| Өр төлбөр | 339.8 | 9,710.7 | 9,370.9 |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 418,040.6 | 540,673.2 | 122,632.6 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 418,380.4 | 550,383.9 | 132,003.5 |

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 15,524.4 мянган төгрөг болж 15,524.4 мянган төгрөгөөр өссөн нь дансны үлдэгдэл төвлөрүүлээгүйгээс шалтгаалжээ.

Бараа материалын дансны үлдэгдэл 36,106.3 мянган төгрөг болж 8,505.7 мянган төгрөгөөр өссөн хандиваар бараа материал ирснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 420,073.4 мянган төгрөг болж 32,408.1 мянган төгрөгөөр өссөн нь хандиваар ирсэн хөрөнгө нэмэгдсэнээс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 4,500.0 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 90,861.4 мянган төгрөгийн хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Авлага дансны үлдэгдэл 78,679.8 мянган төгрөг болж 75,565.3 мянган төгрөгөөр өссөн нь ковидын вакцин, хэвтэн эмчлүүлэгчдийн зардлын санхүүжилтийг Эрүүл мэндийн даатгалын сангаас олгоогүйгээс шалтгаалжээ.

Өр төлбөр дансны үлдэгдэл 9,710.7 мянган төгрөг болж 9,370.9 мянган төгрөгөөр өссөн нь ковидтой холбоотой ажилчдын илүү цагийн хөлс олгоогүй, эмийн үнийн өглөг үүссэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 540,673.2 мянган төгрөг болж 122,632.6 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 324,483.3 мянган төгрөгөөр буюу 72.1 хувиар өссөн байна.

Нийт зардал өмнөх оноос 213,309.8 мянган төгрөгөөр буюу 51.2 хувиар өссөн байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 649,322.8 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 649,322.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 191,353.0 мянган төгрөгөөр бууруулж 459,308.0 мянган төгрөгөөр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 459,308.0 мянган төгрөгийн төсөв баталснаас 402,288.2 мянган төгрөгийг улсын төсвөөс, 34,106.6 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс, 22,913.2 мянган төгрөгийг эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 402,288.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 34,106.6 мянган төгрөг, эрүүл мэндийн даатгалын сангаас 18,530.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 440,570.3 мянган төгрөгийг зарцуулж 6,804.9 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 440,570.3 мянган төгрөг буюу 95.9 хувьтай байгаа нь 6,804.9 мянган төгрөг төвлөрүүлж, Эрүүл мэндийн даатгалын сангаас 4,382.4 мянган төгрөгийн санхүүжилт дутуу ирж, мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 7,550.3 мянган төгрөг байгаатай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 131,894.9 мянган төгрөгийг бүрдүүлжээ.

Үүнээс 123,920.8 мянган төгрөгийг зарцуулж 7,974.1 мянган төгрөгийн дансны үлдэлтэй байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

АОУС 706.7-д тодорхойлсон тодорхой бус байдал үүссэн, хэрэглэгчдэд хамааралтай санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудалгүй болно.

3.8 Аудитын гол асуудал

АОУС 706.1-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх асуудлууд байхгүй болно.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан ерөнхий чиглэлийн дагуу Санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх онд зөвлөмж, албан шаардлага өгсөн болон эрсдэл бүхий байгууллагыг түүвэрт хамруулан шалгасан. Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төвийн хувьд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил өмнөх аудитаар илрээгүй байсан тул Шилэн дансны үйл ажиллагаа, мэдээлэлд хийх нийцлийн аудитаар шалгахаар шийдвэрлэв.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 137, хугацаа хоцроож 12 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна. Хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Бусад хууль тогтоомжийн хүрээнд зөрчилтэй асуудал байхгүй байна.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих төлбөрт үйлчилгээний орлогын авлага 77,015.3 мянган төгрөг байна. Тухайн авлагын дагуу 2022 оны 1 дүгээр сард санхүүжилтийг олгосон байна. Дараагийн аудитаар тухайн авлагын зарцуулалтыг нарийвчлан шалгах нь зүйтэй гэж үзлээ.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9,178.6 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 9,178.6 мянган төгрөгийн 1 зөрчилд албан шаардлага, 2 зөвлөмж өгсөн.

4.3 Албан шаардлага

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төв нь 2021 онд 9178.6 мянган төгрөгийн 3996 литр шатах тослох материалыг олгохдоо жагсаалт үйлдээгүй, зарцуулахдаа замын хуудас хөтлөөгүй, зарцуулалтын тооцоо бодохгүй хяналтгүйгээр зарцуулж, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13-р зүйлийн 13.4 дэх хэсэгт “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно”, 20 зүйлийн 20.1.4 заалтад “Хүчин төгөлдөр бус анхан шатны баримтаар, эсхүл анхан шатны баримтаар баталгаажаагүй ажил, гүйлгээг бүртгэхгүй байх” гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй алдаа зөрчилд албан шаардлага өглөө.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. *Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

1.1. *Илрүүлэлт:*

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төвийн хөрөнгө зарцуулсан тушаалууд гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажаагүй байна.

1.2. *Өгсөн зөвлөмж:*

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” гэж заасныг мөрдөж ажиллах

2.1 *Илрүүлэлт:*

Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төв нь үр дүнгийн урамшуулал олгохдоо ажил дүгнэсэн үнэлгээтэй уялдуулаагүй байна.

2.2 *Өгсөн зөвлөмж:*

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 хавсралтын 2.5-д “Энэ журмын 2.4-т зааснаас бусад төрийн албан хаагчид үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн гэрээнд заасан ажил үүргийн биелэлт, ажлын гүйцэтгэлийн үр дүнг үндэслэн олгоно” гэж заасныг мөрдөж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

5. Аудитаар илэрсэн алдаа зөрчлийн нэгтгэл

/мянган.төгрөгөөр/

| № | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-------------|-------------------------------------|----------------------|----------------|-----------|-----|---------------|-----|-----------------|----------------|----------|------------|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Бөхмөрөн сумын Эрүүл мэндийн төв | 3 | 9,178.6 | | | | | 1 | 9,178.6 | 2 | 0.0 |
| НИЙТ | | 3 | 9,178.6 | | | | | 1 | 9,178.6 | 2 | 0.0 |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР  /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Б.АВИРМЭД/

2022 оны 02 сарын 23-ны өдөр